



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР**

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР**

Редактор: Б.Бямбасүрэн /Бодлогын судалгааны тасгийн дарга/

Эмхэтгэл: Б.Болортуул /Бодлогын судалгааны тасаг/

Б.Бүжинлхам /Бодлогын судалгааны тасаг/

Хэвлэлийн эх бэлтгэл, дизайн: С.Отгонсүх

Хэвлэлийн хэмжээ: 176x250 /B5/

Хэвлэлийн хуудас: 6 х.х

Хэвлэгдсэн тоо ширхэг: 1000ш

АГУУЛГА

ӨМНӨТГӨЛ	4
НЭГ. “КОВИД-19” ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО.....	7
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО.....	9
Эрүүл мэнд	
Биеийн тамир	
Боловсрол	
Нийгмийн халамж	
Хөдөлмөр эрхлэлт	
Соёл урлаг	
Гэр бүл	
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО.....	20
Санхүү, төсвийн зохицуулалт	
Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновац	
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	
Аялал жуулчлал	
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО.....	26
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	30
Ногоон байгууламж бүхий хот	
Утаагүй хот	
Хөрс, орчны бохирдолгүй хот	
Экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан хот	
ЗУРГАА. НИЙСЛЭЛБАБҮС, ОРОННУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО.....	35
Орон зайн оновчтой төлөвлөлт	
Олон төвт хот	
Ухаалаг технологи	
Нийслэлийн газрын харилцаа	
Хотын стандарт	
Орон сууц, нийтийн аж ахуй	
Бүс, орон нутгийн хөгжил	
Дэд бүтэц	
Авто зам	
Тээвэр, логистик	
Инженерийн бэлтгэл арга хэмжээ	
Ус хангамж, ариутгах татуурга	
Эрчим хүч	
Мэдээлэл холбоо	

ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын Их Хурлаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2020 оны 52 дугаар тогтоолоор Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг болох “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг батлагдаж мөрдөгдөж эхлэсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дүгээр тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны бодлогын баримт бичиг, 24 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” тус тус батлагдсан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/1076 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг, 6 Дэд ажлын хэсэг нь “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд Нийслэлийн Монгол Ардын намын хорооноос дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртэй уялдуулан, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, нийслэлийн хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн, нэгдмэл цогц, харилцан уялдаатай, давхардалгүй, хүртээмжтэй, бүх нийтийн оролцоог хангасан байх зарчмуудыг баримтлан **“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”** төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” төлөвлөлтийн баримт бичгийн бүтцийн дагуу **6** бүлэг, **22** тэргүүлэх зорилт, **132** зорилтуудыг дэвшүүлэн боловсруулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/10 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 02/10

Улаанбаатар хот

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн
2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 “д”, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/6524 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д даалгасугай.

2.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур зүүлэлт, хүрэх түвшний хамт батлах;

2.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг жил бүрийн нийслэлийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

2.3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудын биелэлтийг гаргаж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;


2.4.Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө батлагдсаны дараа түүнд суурилсан Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх

3.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д үүрэг болгосугай.

1110100084

4.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, чиглэл өгч ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН



НЭГ. “КОВИД-19” ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

1.1. “Ковид-19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагуудын салбар хоорондын харилцан ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж, эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.1.1. Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

1.1.1.1. Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодоор нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, ариутгал, халдваргүйжүүлэлт, хяналт шалгалтын нэгдсэн цэгийг Эмээлт, Ар гүнт, Таван толгой, Багахангай дүүрэгт шинээр байгуулж, болзошгүй эрсдэлээс хамгаална.

1.1.1.2. Цар тахлаас урьдчилан сэргийлэх болон өвчний тохиолдол нэмэгдсэн үед нийслэл, дүүргийн Эрүүл мэндийн төвийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай эрүүл мэндийн хамгаалал, эм, эмийн хэрэгсэл, хээрийн эмнэлэг дэлгэх бэлэн байдлыг хангана.

1.1.1.3. Худалдаа үйлчилгээний байгууллага, зах, томоохон худалдааны төвүүдийн эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд хяналт тавина.

1.1.1.4. Ариутгал, халдваргүйтгэл хийх бодисын нөөц бүрдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, автобусны буудал, нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулна.

1.1.1.5. Нөхцөл байдлын мэдээллийг олон нийтэд үнэн зөв хүргэх, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэнэ.

- 1.1.2. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотой харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоож, хүндрэлийг даван туулах арга хэмжээ авна.
 - 1.1.2.1. Нийслэлийн Гамшгаас хамгаалах албадад “Шуурхай штаб” байгуулж, тохиолдлын голомтод үүрэг гүйцэтгэх шуурхай арга хэмжээний багийн бэлэн байдлыг ханган ажиллана.
 - 1.1.2.2. Шаардлагатай тохиолдолд харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтооно.
 - 1.1.2.3. Хөл хорионы үед үйл ажиллагаа явуулах төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлах, хяналт тавих ажлыг зохион байгуулна.
 - 1.1.2.4. “Ковид-19” цар тахлын голомт, ойрын болон дам хавьтагчдыг илрүүлж тухайн бүсэд хязгаарлалт тогтоон тархалтыг зогсоох арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - 1.1.2.5. Хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлнэ.
 - 1.1.2.6. Улаанбаатар хотод тусгаарлан ажиглах байраар ханган, байрны нөөц бүрдүүлж, бэлтгэл бэлэн байдлыг хангана.
 - 1.1.2.7. Зорилтот бүлгийн өрх, иргэнд шаардлагатай тусламж, дэмжлэгийг цаг алдалгүй хүргэх ажлыг зохион байгуулна.
- 1.1.3. Халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - 1.1.3.1. Хөл хорионоос үүдэлтэйгээр үйл ажиллагаа нь зогссон жижиг дунд бизнес эрхлэгчдэд Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.
 - 1.1.3.2. Цар тахлын үед ажлын байраа хадгалсан, нэмэгдүүлсэн аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих механизмийг бий болгоно.
 - 1.1.3.3. Цар тахлын нөлөөнд ихээр өртсөн салбаруудыг дэмжсэн, тусгайлсан бодлогыг хэрэгжүүлнэ.



ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ЭРҮҮЛ МЭНД

2.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл амьдралын дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, цахим үйлчилгээг өргөжүүлэх “Эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.1. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин эмгэг, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг тандах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх замаар нас баралтын хувийг бууруулна.

2.1.1.1. Халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээг сайжруулна.

2.1.2. Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна.

2.1.2.1. БЗДХ/ДОХ, сүрьеэ халдварт гепатит болон бусад халдварт өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээнд хамруулна.

2.1.2.2. Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна.

2.1.3. Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулна.

2.1.3.1. Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

2.1.3.2. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна.

2.1.4. Гэр бүлийн гишүүн бүрд эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох ажлыг шат дараатай хийнэ.



- 2.1.4.1. Өсвөр насны хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг сайжруулж, эрүүлжүүлнэ.
- 2.1.4.2. Нөхөн үржихүйн насны зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглээг нэмэгдүүлэх, гэр бүлийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлнэ.
- 2.1.4.3. Жил бүр шат дараатайгаар 1-2 дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.
- 2.1.4.4. Эрүүл мэндийг дэмжих төвийг 8 дүүрэгт байгуулна.
- 2.1.4.5. Дүүрэг бүрд Нийгмийн Эрүүл мэндийн төвийг байгуулна.
- 2.1.5. Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлж, чадавхжуулан, нийгмийн баталгааг хангана.
 - 2.1.5.1. Эрүүл мэндийн ажилтныг ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, гадаад харилцааг хөгжүүлнэ.
 - 2.1.5.2. Хүний нөөцийн тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - 2.1.5.3. Эрүүл мэндийн ажилтны эрүүл, аюулгүй шаардлага хангасан орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаална.
- 2.1.6. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - 2.1.6.1. Нийслэлд эмнэлгийн тусламж үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай бүсчилсэн сүлжээг байгуулна.
 - 2.1.6.2. Дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийг хамтын удирдлагатай, хагас бие даасан засаглалд үе шаттайгаар шилжүүлнэ.
 - 2.1.6.3. Хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
 - 2.1.6.4. Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг сайжруулна.
 - 2.1.6.5. Нийслэлийн Наркологийн эмнэлгийн барилгыг барьж, ашиглалтад оруулна.



- 2.1.6.6. Гачуурт тосгоны Эрүүл мэндийн төвийн барилгыг барьж ашиглалтад оруулна.
- 2.1.6.7. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, автомашинаар шат дараалан хангаж, шинэчилнэ.
- 2.1.6.8. Жишиг нэгдсэн эмнэлгийн загвараар Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт нэгдсэн эмнэлэг байгуулна.
- 2.1.6.9. Баянзүрх дүүрэгт төрийн өмчийн нэгдсэн эмнэлэг байгуулна.
- 2.1.6.10. Иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, өрхийн эмнэлгийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн хүрээнд оновчтой зохион байгуулж, цогцолбор байдлаар хөгжүүлнэ.

БИЕИЙН ТАМИР

2.2. Иргэдийг нийтийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана.

- 2.2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгож, иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - 2.2.1.1. Дүүргүүдийн Биеийн тамир, спортын хорооны бүтцийг боловсронгуй болгож удирдлага зохион байгуулалтыг сайжруулна.
 - 2.2.1.2. Дүүргүүдийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйчтэй болох асуудлыг шийдвэрлүүлнэ.
 - 2.2.1.3. Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг чанаржуулах зорилгоор спортын клубүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг зохион байгуулна.
 - 2.2.1.4. Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.



- 2.2.1.5. Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 2.2.2. Нийслэлд үндэсний спорт болон бусад спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэнэ.
 - 2.2.2.1. Багийн спортыг дэмжих замаар өсвөрийн хүүхэд, багачуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.
 - 2.2.2.2. Биеийн тамир, спортын төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэлд тулгуурлан спортын уралдаан тэмцээнүүдийн чанар зохион байгуулалтыг сайжруулна.
 - 2.2.2.3. Олон улсын залуучуудын ногоон наадмыг зохион байгуулна.
 - 2.2.2.4. Зүүн Азийн Залуучуудын Анхдугаар наадмыг өндөр түвшинд зохион байгуулна.
 - 2.2.2.5. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.3. Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - 2.2.3.1. Олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай шинэ цэнгэлдэх хүрээлэн шинээр барина.
 - 2.2.3.2. Нийслэл болон Сүхбаатар, Баянзүрх, Налайх, Баянгол, Багахангай дүүргийн спортын 6 цогцолборыг барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
 - 2.2.3.3. Нийслэлийн дэд төвүүдэд биеийн тамир спортын барилга байгууламж, төрөлжсөн задгай талбайг төлөвлөх, барих асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
 - 2.2.3.4. Биеийн тамир, спортын хуучин талбайнуудыг эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгжтэй зөвшилцөн эргүүлэн авах, уг талбайнуудыг нийтийн эдэлбэр газраар үлдээж, сэргээн засна.
 - 2.2.3.5. Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир спортын талбайнуудыг стандартын дагуу тохижуулах, аж ахуйн нэгжид олгосныг цуцалж, сургуулийн эзэмшил газарт нь нэмж баталгаажуулна.



БОЛОВСРОЛ

2.3. Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлсэн, суралцагчийн хөгжлийг дэмжсэн "Нийслэлийн боловсрол" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.3.1. Багшийг хөгжүүлж, ур чадварыг нь сайжруулах "Чадвартай багш-Чанартай боловсрол" төслийг хэрэгжүүлж, мэргэжлийн багшийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

2.3.1.1. Багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна.

2.3.1.2. Багш ажлын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлэх, сурлагын амжилт, чанарыг ахиулах зорилгоор индексийн урамшуулал олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулна.

2.3.1.3. Боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, дэмжин ажиллаж, багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх механизм бий болгон хэрэгжүүлнэ.

2.3.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэн, барилга ашиглалт, ачааллын коэффициентыг бууруулж, хүүхдийн хөгжлийг бүх талаар дэмжинэ.

2.3.2.1. Цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх замаар сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жинг 89.0 хувьд хүргэнэ.

2.3.2.2. Сургуулийн барилгыг шинээр барих, өргөтгөх замаар ерөнхий боловсролын сургуулийн барилгын ашиглалт, ачааллын коэффициентыг бууруулж, 1.46 хувьд хүргэнэ.

2.3.2.3. Төгсөх ангийн сурагчдын сурлагын амжилтыг ахиулах зорилгоор "Амжилтын гараа" уралдааныг зохион байгуулна.

2.3.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ.

2.3.3.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт их засвар, дулаан техникийн шинэчлэлийн төслийг хэрэгжүүлж сургалтын орчинг сайжруулна.



- 2.3.3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчныг бүрдүүлж, тусгай хэрэгцээтэй боловсролын багш, хүний нөөцийг хөгжүүлэх замаар боловсролд тэгш хамран сургах нөхцөлийг сайжруулна.
 - 2.3.4.1. Ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчинг бүрдүүлнэ.
 - 2.3.4.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалт зохион байгуулна.
- 2.3.5. Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол хүнсээр хангана.
 - 2.3.5.1. Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлнэ.
 - 2.3.5.2. Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд цахим захиалгын систем нэвтрүүлнэ.
- 2.3.6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн цахим бүртгэл элсэлтийг үргэлжлүүлэх, мэдээллийн болон удирдлагын системийг боловсронгуй болгох, цахим контент хөгжүүлэх замаар бүх шатны боловсролын байгууллагын цахим хэрэглээ, үйлчилгээг нэмэгдүүлнэ.
 - 2.3.6.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүртгэл, элсэлтийг цахимаар зохион байгуулна.
 - 2.3.6.2. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээнд цахим хичээлийн иж бүрэн сан, даалгаврын сан бүрдүүлэн интернетэд байршуулж, сурагчид үнэ төлбөргүй үзэх замаар бие даан суралцах боломжийг нэмэгдүүлнэ.
 - 2.3.6.3. Ерөнхий боловсролын сургуулиудад интерактив цахим хичээл явуулах програм хангамж, дэд бүтцийн боломжийг бүрдүүлнэ.
- 2.3.7. Сургуулийн бүсэд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчинг бүрдүүлж, суралцагч гэр сургуулийн хооронд үнэ төлбөргүй зорчих “Хүүхдийн автобус” төсөл хэрэгжүүлнэ.



- 2.3.7.1. Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, авто замын ачааллыг бууруулах зорилгоор “Хүүхдийн автобус” төслийг хэрэгжүүлнэ.
- 2.3.7.2. Сургуулийн орчин дахь гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, хурд сааруулагчийг нэмэгдүүлж, хүүхдийг зам тээврийн осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

2.4. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт бодлогыг хэрэгжүүлнэ.

- 2.4.1. Зорилтот бүлгийн өрх, иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулна.
 - 2.4.1.1. Ажил эрхэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдийг амьдралын зөв дадал хэвшилд сургах, түр хоноглох үйлчилгээнд хамруулна.
 - 2.4.1.2. Зорилтот бүлгийн өрх, иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан, хамт олны бүлэг бүрдүүлэн орлогын эх үүсвэртэй болох нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлж, нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох оролцоог нэмэгдүүлнэ.
 - 2.4.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.5. Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

- 2.5.1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжин цагаар ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 2.5.1.1. Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.



- 2.5.1.2. Оюутан, залуучуудыг цагаар ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэн, суралцах хугацаанд нь хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй болгоно.
- 2.5.2. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
 - 2.5.2.1. Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн систем болон цахим хөдөлмөрийн биржийг хөгжүүлэх замаар үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - 2.5.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон цагийн болон түр ажлын байрыг нэмэгдүүлнэ.
 - 2.5.2.3. Мэргэжлийн болон давтан сургалтад иргэдийг хамруулан, тохирох ажлын байранд зуучилна.
 - 2.5.2.4. Бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын цагийг богиносгох замаар байгууллагын урсгал зардлыг бууруулах мэдээлэл, нөлөөллийн аян зохион байгуулна.
 - 2.5.2.5. Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах өдөрлөгийг тогтмол зохион байгуулна.
 - 2.5.2.6. Ажил олгогч, аж ахуй нэгж байгууллагуудад зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.

ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ

СОЁЛ УРЛАГ

2.6. Үндэсний агуулга бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ.

- 2.6.1. Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн соёл, урлагийн байгууллагын шинэ барилга байгууламжуудын гадна тохижилт, газрын асуудлыг шийдвэрлэнэ.
 - 2.6.1.1. Үндэсний номын сангийн хуучин барилга, Дуурь бүжгийн Эрдмийн театр, Драмын Эрдмийн театрын барилгуудыг сэргээн засварлана.



- 2.6.1.2. Үндэсний урлагийн их театр, Үндэсний номын сан, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн соёлын өв, хөгжлийн төв, Хүүхэд залуучуудын театрын барилгыг шинээр барих газрын асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.6.2. Улаанбаатар хотын музей болон Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
 - 2.6.2.1. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан болон салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн Соёлын ордны номын санд фондын баяжилтыг жил бүр хийнэ.
 - 2.6.2.2. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан болон салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн Соёлын ордны номын санд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 2.6.2.3. Улаанбаатар хотын музейн барилгыг засварлаж үйл ажиллагааг боловсрол, түүх соёлын танин мэдэхүйн чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлнэ.
- 2.6.3. Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна.
 - 2.6.3.1. “Хотын соёл” цуврал контент бий болгож, цахим аян хэрэгжүүлнэ.
- 2.6.4. Урлагийн олон төрөл зүйлийг жигд хөгжүүлж, иргэд, олон нийт болон гадаадын жуулчдад сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлж, үндэсний агуулга шингэсэн бүтээлийн тоог нэмэгдүүлнэ.
 - 2.6.4.1. Үндэсний агуулга шингэсэн уран бүтээлийг дэмжинэ.
 - 2.6.4.2. “Улаанбаатар” олон улсын кино наадам, Сонгодог урлагийн гала фестивалийг жил бүр зохион байгуулна.
 - 2.6.4.3. Иргэд, жуулчдад зориулсан нийтийг хамарсан урлагийн тоглолт, үйл ажиллагаа зохион байгуулна.
- 2.6.5. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг оюуны өмч зохиогчийн эрх, инновацид тулгуурлан хөгжүүлнэ.
 - 2.6.5.1. Улаанбаатар хотын Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих инкубатор төв байгуулна.



2.6.6. Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, иргэдэд үйлчлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.6.6.1. “Улаанбаатар” чуулгын үйл ажиллагааг өргөжүүлж театрын статустай болгоно.

2.6.7. Улс, нийслэл, дүүргийн хамгаалалтад байх түүх соёлын дурсгалт газар, барилга байгууламжийг бүсчлэн хувааж аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно.

2.6.7.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг танилцуулах, сурталчлах аппликэйшн бүтээж, соёлын аялал жуулчлалын эргэлтэд оруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

ГЭР БҮЛ

2.7. Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжин гэр бүлийн тогтвортой байдлыг хангах “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.7.1. Гэр бүлийн гишүүн бүрд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийг ажлыг зохион байгуулж, гэр бүлийн тогтвортой байдлыг ханган, хүчирхийллийг бүх хэлбэрийг устгана.

2.7.1.1. Гэр бүлд боловсрол, зөвлөгөө өгөх төв байгуулна.

2.7.1.2. Гэр бүлийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

2.7.1.3. Гэр бүлийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг талуудтай хамтран зохион байгуулна.

2.7.1.4. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна.

2.7.1.5. Хохирогчид үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжид тогтмол хяналт тавьж, арга зүйгээр хангана.

2.7.1.6. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төв байгуулсан байна.

2.7.1.7. Анхаарал хариуцлага эрсдэлгүй орчин аян өрнүүлнэ.

2.7.2. Хүүхдийг осол гэмтэл, болзошгүй эрсдэл, цахим орчны сөрөг



- нөлөөлөл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 2.7.2.1. Хараа хяналтгүй, хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх “Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулна.
- 2.7.2.2. Улаанбаатар хотын хүүхдэд ээлтэй байдлын индексийг тогтоож, индексийн үзүүлэлтийг сайжруулна.
- 2.7.3. Нийслэлийн Залуучуудын хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, залуучуудын хөгжлийг дэмжинэ.
- 2.7.3.1. Залуучуудын хөгжлийн төвийг байгуулан, өсвөр үе залуучуудыг сөрөг зан үйл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулна.
- 2.7.3.2. Зорилтот бүлгийн залуучуудын амьдралын чанарыг сайжруулах, нийгэмшүүлэх хөгжлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

САНХҮҮ, ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1. Нийслэлийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулна.

3.1.1. Нийслэлийн өмчийн хөрөнгийн зах зээлийн бодит үнэлгээг тогтоож, өмч ашиглалтыг эргэлтэд оруулна.

3.1.1.1. Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.

3.1.1.2. Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компани төрийн өмчит компанийн тоог бууруулна.

3.1.1.3. Нийслэлийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.

3.1.1.4. Нийслэлийн хэмжээнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

3.1.2. Улаанбаатар хотын хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын сан, үнэт цаас гаргана.

3.1.2.1. Хөрөнгө оруулалтын сан байгуулна.

3.1.2.2. Бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор үнэт цаас гаргана.

3.1.3. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, олон улсын байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахад бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хамтран ажиллана.

3.1.3.1. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, "Эдийн засгийн чөлөөт бүс" байгуулах ТЭЗҮ боловсруулна.



- 3.1.3.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, эрх ашгийг хамгаална.
- 3.1.3.3. Олон улсын донор байгууллагуудтай нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэх санхүүгийн үр ашигтай хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлнэ.
- 3.1.3.4. Бүс нутгийн хотуудтай харилцан ашигтай худалдаа, эдийн засаг болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 3.1.4. Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар төсвийн алдагдлыг бууруулж, сахилга батыг сайжруулна.
 - 3.1.4.1. Цахим зайн ажлын байр, ажлын уян хатан цагийг дэмжих замаар эдийн засгийн зохистой хэмнэлтийг хийнэ.
 - 3.1.4.2. Татвар ногдуулах, хураах үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэн, хялбаршуулна.
 - 3.1.4.3. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийг нэвтрүүлнэ.

ШИНЖЛЭХ УХААН, ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦ

3.2. Хотыг үйлдвэрлэл, инновацын төв болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.

- 3.2.1. Нийслэлд инновацын соёлыг бий болгох, түгээх нийслэлийн инновацыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.2.2. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг үе шаттайгаар байгуулна.
 - 3.2.2.1. Налайхын “Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” –ийн дэд бүтцийг байгуулна.
 - 3.2.2.2. “Багануур үйлдвэрлэл технологийн парк” –ийн дэд бүтцийг байгуулна.
 - 3.2.2.3. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” –ийн дэд бүтцийг байгуулна.
 - 3.2.2.4. “Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк” –ийн дэд бүтцийг байгуулна.

3.2.3. Инновац, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг дэмжих инновацын төвүүдийг байгуулна.

3.2.3.1. Инновацын төвүүдийг байгуулна.

3.2.3.2. Бүтээгчдийн талбарыг дэд төвүүдийг түшиглэн байгуулна.

3.2.4. Шинэ технологи бүтээж, нэвтрүүлэх болон инновацын судалгаа хөгжүүлэлтийг эдийн засгийн хөшүүргээр дэмжих механизм бий болгоно.

3.2.4.1. Нийслэлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд шинэ санаа, шилдэг инновацыг нэвтрүүлнэ.

3.2.5. Инновацын төвүүдэд гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.5.1. Гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулж, хөгжүүлнэ.

3.2.5.2. Инновацын төвүүдэд бойжиж буй гарааны бизнес эрхлэгчдийг бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц, арга хэмжээг зохион байгуулна.

3.2.5.3. “10,000 программист” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭР

3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангана.

3.3.1. Нийслэлд эрчимжсэн аж ахуйг кластер байдлаар төрөлжүүлэн хөгжүүлнэ.

3.3.1.1. Эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, малын генетик нөөцийн төлөвт тохирсон бүс нутгийн үржүүлгийн арга технологийг нэвтрүүлнэ.

3.3.1.2. Эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцсэн мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх малын зах, мах боловсруулах үйлдвэрийг цогцоор байгуулна.

3.3.1.3. Мал амьтныг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах,



усалгаа, өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.

- 3.3.1.4. Нийслэлийн хүн амын хаврын махны хангамж, үнийг тогтвортой хадгалах зорилгоор мах бэлтгэн нөөцлөх, худалдан борлуулах ажлыг зохион байгуулна.
- 3.3.2. Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулж, хүн амын хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хамгаална.
 - 3.3.2.1. Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, тандалт, хяналтыг сайжруулан тайван байдлыг хадгална.
 - 3.3.2.2. Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхийг эд бүтээгдэхүүний дээжид шинжилгээ хийж, нийслэлийн хүн амын хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хамгаална.
 - 3.3.2.3. Мал эмнэлгийн шуурхай бэлэн байдлыг хангах ариутгал халдваргүйтгэлийн хүн, мал, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг шат дараатайгаар нэвтрүүлнэ.
- 3.3.3. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн аж ахуй эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, иргэдэд эрүүл, баталгаатай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдан борлуулах сүлжээг боловсронгуй болгоно.
 - 3.3.3.1. Өвөл, зуны хүлэмжийн болон зоорийн аж ахуйг хөгжүүлэн, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хот, суурингийн хүн амын хүнсний ногооны гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангана.
 - 3.3.3.2. “Алтан намар” арга хэмжээний хүрээнд эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг зохион байгуулна.
 - 3.3.3.3. Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.
 - 3.3.3.4. Хүнсний боловсруулах үйлдвэрүүдэд зохистой дадал, удирдлагын тогтолцоо, стандартыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

3.4. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

3.4.1. Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.

3.4.1.1. Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг нэмэгдүүлнэ.

3.4.1.2. Улаанбаатар хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлж, соёл, аялал жуулчлалын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, шинэ аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.

3.4.2.1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад, дотоодод түгээн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.4.3. Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3.4.3.1. Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.4.3.2. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад тавигдах ерөнхий шаардлагад нэмэлт оруулах замаар и-баримтад бүрэн холбож, нийслэл хотын албан татвараас төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.

3.4.4. “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.4.5. Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

3.5. Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн ажлын байрыг хадгалах, хамгаалах, ур чадварыг хөгжүүлэх, олон улсын зах зээлд бараа бүтээгдэхүүний борлуулалтыг зуучлах, хөрөнгө оруулалтыг татах замаар тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлнэ.

3.5.1. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, бизнесийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, тулгамдаж буй хүндрэлийг арилгахад анхаарч, эрх ашгийг хамгаалж ажиллана.

3.5.2. Ажлын байрыг хадгалсан, нэмэгдүүлсэн бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.

3.5.3. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг ил тод, хүртээмжтэй мэдээллээр хангах, эдийн засгийн хөшүүргээр дэмжих механизмыг боловсронгуй болгоно.

3.5.3.1. Олон улсын сайн туршлага, санхүүгийн байгууллагуудын эрэлт, хэрэгцээг судалж, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлж, төрөлжсөн сургалт зохион байгуулна.

3.5.3.2. Бичил, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зээлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, үйлдвэрлэл эрхлэгчдийн зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх зээл олгох нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.

3.5.4. Бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин, гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн борлуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжин ажиллана.

3.5.4.1. Дотоодын болон олон улсын үзэсгэлэн, яармаг зохион байгуулах, оролцоход дэмжин, тусална.

3.5.4.2. Цахим худалдааг хөгжүүлэх чиглэлээр ажиллана.

3.5.5. Томоохон аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийг бичил, жижиг, дунд үйлдвэрүүдтэй холбож, ханган нийлүүлэлтийг бий болгон, хөгжүүлнэ.



ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно.

4.1.1. Төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг “Нэг цонхны үйлчилгээ”-нд шилжүүлэн, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх бага зардал, цомхон бүтэц бүхий төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн байгуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

4.1.1.1. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг нэг цонхны үйлчилгээнд үе шаттай шилжүүлнэ.

4.1.1.2. Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлнэ.

4.1.2. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд үйлчилгээний стандартыг нэвтрүүлнэ.

4.1.2.1. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн “Брэндбүүк”-ийг бүтээнэ.

4.1.2.2. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.

4.1.3. Нийслэлийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгоно.

4.1.3.1. Харилцаа холбоо, мэдээллийн дэвшилтэт технологийг ашиглан иргэн төвтэй, ухаалаг үйлчилгээг үзүүлэх, “Цахим засаглал” төсөл хэрэгжүүлнэ.



- 4.1.3.2. Улаанбаатар хотын алслагдсан гэр хороолол болон хүн ам ихээр цуглардаг тодорхой бүсүүдийг үе шаттайгаар утасгүй интернетжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.1.4. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.
 - 4.1.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.

4.2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.

- 4.2.1. Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчит, аж ахуйн тооцоот байгууллагуудын чиг үүргийн давхардал, үйл ажиллагааны хийдлийг арилгаж, захиргааны төвлөрлийг сааруулна.
 - 4.2.1.1. Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчит, аж ахуйн тооцоот байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийж, ажил үүргийн давхардалгүй болно.
 - 4.2.2.2. Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны зөвшөөрлийн тоог цөөрүүлж, зөвшөөрөл олгох нөхцөл журмыг тодорхой ойлгомжтой болгон цахимжуулж, хяналт шалгалтыг цөөрүүлнэ.
- 4.2.2. Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.
 - 4.2.2.1. Төрийн албан хаагчийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, авлига, хээл хахууль авсан гэмт хэргийн гаралтын тоог бууруулна.
- 4.2.3. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.



4.2.3.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлнэ.

4.2.3.2. Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд Улаанбаатар хоттой ах дүүгийн болон Найрамдалт харилцаат хотуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулна.

4.3. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.

4.3.1. Гудамж, зам талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хулгайлах гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийн мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулж, камерын хяналтын нэгдсэн системийг байгуулан, гэмт хэргийн гаралтыг бууруулна.

4.3.1.1. Нийслэлийн удирдлага, хяналт, зохицуулалтын нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

4.3.1.2. Бичлэг болон зурган мэдээллээс үл давтагдах өгөгдлөөр программ хангамжийг нэвтрүүлэх, гэмт хэргийн /Griemtar, Compstat/ цахим зураглалыг Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлуудыг хийж, камерыг “Камерын удирдлагын нэгдсэн төв”-тэй холбоно.

4.3.2. Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.

4.3.2.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хохирогчийг хамгаалалтад авах, аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрыг барьж ашиглалтад оруулна.

4.3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг сайжруулж, цагдаагийн байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.

4.3.3.1. Цагдаагийн байгууллагын хэлтэс, хэсгийн тоог нэмэгдүүлж, шинээр барина.

4.3.3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай автомашин, техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлнэ.



- 4.3.3.3. Эрүүлжүүлэх, саатуулах төвийн барилгыг шинэчлэн барьж, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг сайжруулсан байна.
- 4.3.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог хангана.
 - 4.3.4.1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, “Олон нийтийн цагдаа”, “Оюутан цагдаа” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
 - 4.3.4.2. Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах “Хүүхэд хамгаалагч” төслийг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэгт өртөх, хохирогч болох эрсдэл бууруулсан байна.
- 4.3.5. Иргэдийг гамшгаас цаг алдалгүй авран хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - 4.3.5.1. Хүн амын нягтрал ихтэй байршлуудад гал түймэр унтраах, аврах анги байгуулна.
 - 4.3.5.2. Онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх техник, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлнэ.



ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

НОГООН БАЙГУУЛАМЖ БҮХИЙ ХОТ

5.1. Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, хотыг цэцэрлэгжүүлэх, ойжуулах, тохижилт бүхий гудамж, талбайг бий болгож, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.1. Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

5.1.1.1. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цэцэрлэгт хүрээлэн байгуулж, олон нийтийн амралт зугаалгын талбайг нэмэгдүүлнэ.

5.1.1.2. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг үргэлжлүүлнэ.

5.1.1.3. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтын менежментийн ажлыг сайжруулна.

5.1.1.4. Гэр хорооллын айл өрх хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачилгыг дэмжиж ажиллана.

5.1.1.5. “Шарилжгүй Улаанбаатар” аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

5.1.2. Хотын тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.

5.1.2.1. Иргэд, олон нийтэд биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор стандартад нийцсэн спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулна.



- 5.1.2.2. Эмнэлгүүдийн гаднах зам талбайг тохижуулна.
 - 5.1.2.3. Сургууль, цэцэрлэгийн гадна талбайг тохижуулна.
 - 5.1.2.4. Тохижилтын ажлын үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, бичил тохижилт бүхий амралт, спортын талбайг сэргээн засварлах ажлыг зохион байгуулна.
 - 5.1.2.5. Түүх, соёлын дурсгалт газруудын орчныг тохижуулах ажлыг зохион байгуулна.
 - 5.1.2.6. Сул шороон хөрсийг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгож тоосжилтыг бууруулна.
- 5.1.3. Туул, Сэлбэ, Дунд голын урсцыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан, тохилог орчныг бүрдүүлнэ.

5.2. Агаар, орчны бохирдлыг бууруулж, байгальд ээлтэй, үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.

УТААГҮЙ ХОТ

- 5.2.1. Нийслэл хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, агаарын чанарын хяналтыг сайжруулна.
- 5.2.1.1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, түүнд мөрдөх журмыг баталж, хэрэгжүүлнэ.
 - 5.2.1.2. Сайжруулсан түлшний зүүн үйлдвэрийг ашиглалтад оруулна.
 - 5.2.1.3. Гэр хорооллын айл, өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшийг түгээх, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагааг дэмжиж, хяналт тавина.
 - 5.2.1.4. Агаарын чанарын хяналт, шинжилгээний чадавхыг сайжруулж, судалгаа, шинжилгээ хийх хүрээг нэмэгдүүлнэ.
- 5.2.2. Авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.2.2.1. Авто замын хөдөлгөөнд оролцож буй нийтийн болон ачаа тээврийн тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт хийж, стандартад нийцүүлэх арга хэмжээ авна.



5.2.3. Агаарын бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлнэ.

5.2.3.1. Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хий, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар иргэн, хуулийн этгээдэд сургалт зохион байгуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлнэ.

5.2.4. Байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй, дулаан хуримтлуулах, бусад үр ашигтай технологийг нэвтрүүлнэ.

5.2.4.1. Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг халаалтаа дэвшилтэт технологи бүхий шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуураар шийдэх боломжийг бүрдүүлнэ.

5.2.4.2. Нийслэлийн төрийн өмчийн халаалтын зуухыг буулгаж, төвлөрсөн дулаан хангамжид холбоно.

5.2.4.3. Гэр хорооллын байшин, сууцны дулааны алдагдлыг бууруулна.

5.2.5. Агаарын чанарын хяналт, шинжилгээний чадавхыг сайжруулж, судалгаа, шинжилгээ хийх хүрээг нэмэгдүүлнэ.

5.2.5.1. Нийслэлийн агаарын чанарын хяналтын чадавхыг сайжруулж, суурин автомат станцын тоог нэмэгдүүлж, тасралтгүй ажиллагааг хангана.

ХӨРС, ОРЧНЫ БОХИРДОЛГҮЙ ХОТ

5.2.6. Бохирдож доройтсон, үржил шимээ алдсан хөрсийг нөхөн сэргээх хүн амын эрүүл мэндийг хамгаалах, салбар дундын уялдааг хангасан нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх “Хөрсний бохирдолгүй хот” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.2.6.1. Нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.

5.2.6.2. Хөрсний бохирдлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлнэ.



- 5.2.6.3. Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжид шилжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 5.2.6.4. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх оршуулгын үйлчилгээний зохистой менежментийг бий болгож, оршуулгын газруудыг ойжуулна.
- 5.2.7. Хог хаягдлыг ангилах, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихэд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.2.7.1. Улаанбаатар хотын хог хаягдлыг ангилан ялгаж, цуглуулж тээвэрлэх дэвшилтэт цогц арга, технологийг нэвтрүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлүүдийг дэмжих замаар төвлөрсөн цэгт дарж булагдах хог хаягдлын хэмжээг бууруулна.
- 5.2.7.2. Хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийн нөхцөлийг сайжруулж, олон жил хог дарж булсан ландфиллын талбайг үе шаттайгаар хэсэгчлэн нөхөн сэргээлт хийнэ.
- 5.2.7.3. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ.
- 5.2.7.4. Аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлж, ангилан ялгаж, тээвэрлэх, түр хадгалах, саармагжуулан устгах тогтолцоог бий болгоно.
- 5.2.8. Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж, өдөрт 2,000 кг бордоо үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг ашиглалтад оруулна.

ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ ХАНГАСАН ХОТ

5.3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

- 5.3.1. Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын унаган төрхийг хадгалах зорилгоор ач холбогдол бүхий газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авна.
- 5.3.1.1. Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн хэмжээг 20



хувиар нэмэгдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангана.

- 5.3.1.2. Нийслэлийн усны нөөц доройтон хомсдож, бохирдох аюул учирч байгаа эх үүсвэрийг орон нутгийн хамгаалалтад авна.
- 5.3.2. Амьтан, ургамлын төрөл зүйлийг нутагшуулан хамгаалж, нөхөн сэргээнэ.
- 5.3.3. Хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэн ойгоор бүрхэгдсэн талбайг өргөжүүлнэ.
- 5.3.4. Хүн ам төвлөрөн суурьшсан бүс нутаг, хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын судалгааг улсын болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, эрэлт хэрэгцээ, захиалгад үндэслэн хийж, газрын доорх усны ашиглах боломжит нөөцийг тогтоох ажлыг хэрэгжүүлнэ.
- 5.3.5. Ундны усны хамгаалалтыг сайжруулж, гүний усны хэрэглээг бууруулж, гадаргын усыг хуримтлуулан ашиглах боломжийг нэмэгдүүлнэ.
- 5.3.6. Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах стандартыг мөрдүүлнэ.
 - 5.3.6.1. Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ.
- 5.3.7. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн талбайг үе шаттайгаар нөхөн сэргээж, сөрөг нөлөөллийг бууруулна.



ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

УЛААНБААТАР ХОТ

6.1. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ.

ОРОН ЗАЙН ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЛТ

- 6.1.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.
 - 6.1.1.1. Хот байгуулалтын баримт бичиг, зураг төсөл, ТЭЗҮ, мастер төлөвлөгөөг боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ.
 - 6.1.1.2. Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг батлуулна.
 - 6.1.1.3. Нийслэлийн ногоон бүс /зуслан/-ийн 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчилнэ.
 - 6.1.1.4. Хот төлөвлөлтийн норм, дүрэмд заасан хүн амын тооцоот нягтралаас хэтэрсэн газрын судалгааг гаргаж Хүн ам, барилгажилтын нягтралыг хориглох бүсийг шинэчлэн тогтооно.
 - 6.1.1.5. Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулан, хэрэгжүүлнэ.

ОЛОН ТӨВТ ХОТ

- 6.1.2. Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, шинжлэх ухаан, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон

инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж хотын хэт төвлөрлийг бууруулна.

6.1.2.1. “Яармаг” хотын шинэ төвийн ерөнхий төлөвлөгөөг / Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол/ шинэчлэн боловсруулж, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалт хэрэгжих боломжийг бүрдүүлнэ.

6.1.2.2. Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн мянга, Толгойт, Шархад дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгана.

УХААЛАГ ТЕХНОЛОГИ

6.1.3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.1.3.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгоно.

6.1.3.2. Иргэн, хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем нэвтрүүлнэ.

6.1.3.3. Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн Улсын хаягийн нэгдсэн системд бүрэн холбоно.

НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА

6.1.4. Нийслэлийн газрын харилцааны бодлогыг шинэчлэн, цахим системийг нэвтрүүлэн, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

6.1.4.1. Гэр хорооллын мухар гудамж, зуслангийн бүсийн орц, гарц, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай хүргэх, нэвтрэх боломжийг бүрдүүлнэ.



- 6.1.4.2. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажлын нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдэд хуулийн дагуу нөхөн олговрыг олгох, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна.
- 6.1.4.3. Ойн, голын, усан сан бүхий газрын, үер, цэвэрлэх байгууламж, өндөр хүчдэлийн, түүх соёлын дурсгалт зүйлийн хамгаалалтын бүс болон төлөвлөж буй экологийн коридорт орсон, хотын суурьшлын бүс /тэг гортиг/-ийн гадна байгаа суурьшлыг чөлөөлж, нүүлгэн шилжүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулна.
- 6.1.4.4. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, холбогдох шийдвэрийг гаргуулан бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулна.

ХОТЫН СТАНДАРТ

- 6.1.5. Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 6.1.6. Ногоон барилгын стандарт боловсруулж нэвтрүүлсэн байна.

ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ

- 6.1.7. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, газрыг дахин зохион байгуулах төслийг үргэлжлүүлэн, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангах ажлыг эрчимжүүлнэ.
- 6.1.7.1. Төвийн бүсийн гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулж, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангагдсан орон сууцыг ашиглалтад оруулна.
- 6.1.7.2. Дундын бүсийн гэр хороололд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх дэд бүтцийн төв буюу “Сервис центр”-ийг ашиглалтад оруулна.
- 6.1.7.3. Захын бүсийн гэр хороололд бие даасан эх үүсвэр



/сэргээгдэх эрчим хүч, цахилгаан, шингэрүүлсэн болон хийн түлш/ бүхий технологийг нэвтрүүлнэ.

- 6.1.7.4. Гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулахаар төлөвлөгдөж хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь батлагдсан байршлуудад иргэдийн газрыг орон сууцаар сольж, “Нэг яндан - нэг орон сууц” төсөл хэрэгжүүлнэ.
- 6.1.8. Түрээсийн олон төрөлт болон оршин суугчдын орлогод нийцсэн ногоон орон сууцны шинэ хорооллуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.
- 6.1.8.1. Орлогод нийцсэн болон түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 6.1.8.2. Нийслэл үнэт цаас гаргаж зах зээлд бэлэн байгаа орон сууцыг худалдан авч, түрээслээд өмчлөх хэлбэрээр иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.1.8.3. Инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий иргэдийн орлогод нийцсэн ногоон орон сууцыг ашиглалтад оруулна.
- 6.1.8.4. Шинэ суурьшлын бүсүүдэд 5,000 айлын орон сууц ашиглалтад оруулна.
- 6.1.9. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулна.
- 6.1.10. Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.1.11. Барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, хүчитгэлийн зураг боловсруулж, лаборатори байгуулна.
- 6.1.12. Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, стандартыг сайжруулан боловсруулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

6.2. Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, хүн амын



нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж бүс, орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна.

6.2.1. Дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна.

6.2.1.1. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”, “Бүсийн хөгжлийн хөтөлбөр”-тэй Нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулна.

6.2.1.2. Улаанбаатар хотын дагуул, хаяа хот, тосгодын төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

6.2.1.3. “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэст өөрчлөлт оруулж, эхний ээлжийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлнэ.

6.2.1.4. Богдхан уулыг тойрсон “Хөгжлийн алтан тойрог” байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.

6.2.1.5. Улаанбаатар хотын дагуул хотуудыг түшиглэн ачаа тээврийн логистик төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

6.2.1.6. “Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

6.2.1.7. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ.

6.2.1.8. Зарим Их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотууд болон бусад аймгуудад шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ.

6.2.1.9. Төв аймагтай хамтран ажиллах эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн байна.

ДЭД БҮТЭЦ

6.3. Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

АВТО ЗАМ

6.3.1. Улаанбаатар хотын авто замын үндсэн сүлжээг хөгжүүлнэ.

6.3.1.1. Гол, туслах гудамж замыг шинээр барьж, өргөтгөн шинэчилнэ.

6.3.2. Хорооллын доторх гудамж замын сүлжээг хөгжүүлнэ.

6.3.2.1. Хорооллын чанартай авто замыг шинээр барьж, засвар шинэчлэлт хийнэ.

6.3.3. Гудамж замын уулзварыг сайжруулж, олон түвшний уулзваруудыг барина.

6.3.3.1. Уулзваруудад хөдөлгөөн зохион байгуулалт хийж шинэчлэн сайжруулна.

6.3.4. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан төмөр замын гарам, авто машины болон явган хүний гүүрэн гарц, нүхэн гарцуудыг шинээр барина.

6.3.4.1. Төмөрбетон гүүрэн байгууламжийг шинээр барьж, өргөтгөж, шинэчилнэ.

6.3.4.2. Явган зорчигчийн гүүрэн гарцыг авто зам болон төмөр зам дээгүүр барина.

6.3.4.3. Авто машины болон явган зорчигчийн нүхэн гарцуудыг барина.

6.3.5. Дагуул хот, тосгод, хүн амын нутагшилт, суурьшлын зохистой харилцаанд суурилсан хотын хөгжлийг дэмжсэн, зам, тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн хөгжүүлнэ.

6.3.5.1. Дагуул хот, тосгод дотор шинээр авто зам барьж, засвар шинэчлэлт хийнэ.

6.3.6. Тээврийн хэрэгслийн ил, газар доорх, дэвшилтэт технологи бүхий олон давхар зогсоолуудыг шинээр барьж, зогсоолын менежментийг шинэчлэн сайжруулна.



- 6.3.7. Дугуйн болон явган хүний замын сүлжээг хөгжүүлнэ.
 - 6.3.7.1. Явган хүний замыг шинээр барина.
 - 6.3.7.2. Дугуйн зам шинээр барина.
- 6.3.8. Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг хариуцагчийн тогтолцоонд шилжүүлж жилийн аль ч улиралд байнгын бэлэн байдлыг хангуулна.
 - 6.3.8.1. Зам хариуцагчийн эрх зүйн орчныг бүрдүүлж, авто зам засвар арчлалтыг гэрээгээр гүйцэтгүүлнэ.
- 6.3.9. Авто замын бүртгэл мэдээллийн санг хөгжүүлнэ.
 - 6.3.9.1. Нийтийн өмчийн авто замын нэгдсэн кадастрын зураглал бий болгож, бүртгэл мэдээллийн сан үүсгэж, хэрэглэгчдийг мэдээллээр хангана.
- 6.3.10. Авто замын сангийн хөрөнгийн үүсвэрийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
 - 6.3.10.1. Авто замын сангийн хөрөнгийн эх үүсвэрүүдийг бүрэн ашиглаж, замын санг нэмэгдүүлнэ.
- 6.3.11. “Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем” төслийг бүрэн хэрэгжүүлнэ.
 - 6.3.11.1. Тээврийн хэрэгслийн моторын багтаамж, насжилтаар нь хөдөлгөөнд оролцохыг хязгаарласан бүсчлэл тогтооно.
 - 6.3.11.2. Замын хөдөлгөөнд оролцохгүй өдрийг иргэн өөрөө сонгох боломжийг бүрдүүлнэ.
 - 6.3.11.3. Замын хөдөлгөөнийг удирдах, хянах бүртгэх үйл ажиллагааны нэгдсэн ухаалаг дэд системүүдийг нэвтрүүлнэ.
- 6.3.12. Авто замын ачааллыг бууруулах зөв менежментийн үйл ажиллагаа, дэд бүтэц, инженерчлэлийн арга хэмжээ авч ажиллана.
 - 6.3.12.1. Их багтаамжтай зогсоолуудыг байгуулна.
- 6.3.13. Сургууль орчмын авто замуудын тэмдэг, тэмдэглэгээг олон улсын жишигт хүргэж, сургуулийн сурагчид зориулсан тээврийн үйлчилгээний шинэ менежмент нэвтрүүлнэ.



ТЭЭВЭР, ЛОГИСТИК

6.3.14. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглол бүхий тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

6.3.14.1. Цахилгаан эх үүсвэрээр ажилладаг тээврийн хэрэгслүүдийг цэнэглэх цэгүүдийн байршлыг тодорхойлж цэгүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор байгуулна.

6.3.14.2. Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.

6.3.14.3. Төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлийн хүрээнд хотын такси тээврийг хөгжүүлж, менежментийг сайжруулна.

6.3.15. Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг, олон төрөлт тээврийн төслүүдийг хэрэгжүүлнэ.

6.3.15.1. “Агаарын дүүжин замын тээврийн төсөл”-ийг хэрэгжүүлнэ.

6.3.15.2. Өндөр хүчин чадалтай нийтийн тээврийн төслийг хэрэгжүүлнэ.

6.3.16. Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх нэгдсэн терминал, зогсоолуудыг барьж, зорчигчийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.

6.3.17. Хотын зүүн, баруун хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн бөөний худалдааны төв байгуулна.

6.3.18. Ачаа тээврийн удирдлагын системийн нэмэлт хөгжүүлэлтийн програм хангамж боловсруулж, ачаа тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагааг үе шаттайгаар шөнийн горимд шилжүүлнэ.

6.3.19. Нийтийн тээврийн үйлчилгээний хөдөлгөөний бүртгэл, мэдээлэл, хяналт, зохицуулалтын удирдлагын төв байгуулна.

ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭ

6.3.20. Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө болон өндөржилтийн нэгдсэн зураг төсөл боловсруулан батлуулна.



- 6.3.20.1. Нийслэлийн эрсдэлтэй бүсүүдэд гидрогеологийн хэмжилт хийж, хяналтын цооног байгуулж, үерийн хамгаалалтын барилга байгууламжийг үе шаттай төлөвлөх, ажлын зураг төсөл боловсруулах салбарын бодлогын баримт бичигтэй болно.
- 6.3.20.2. Өндөржилтийн зураг төсөл хийгдээгүй 3 дүүргийн зураг төслийг боловсруулна.
- 6.3.21. Голуудын эрэг болон үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн шинэчилнэ.
- 6.3.21.1. Улиастай голын эргийн хамгаалалтын барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна.
- 6.3.21.2. Шинээр Доод өлзийт, Биокомбинат, Туул зэрлэг орчмын үерийн далан сувгийг ашиглалтад оруулж, Баянгол, Нарангийн үерийн сувгийг үргэлжлүүлнэ.
- 6.3.21.3. Шинээр хорооллын чанартай төв зам дагуу зам, талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээг барьж ашиглалтад оруулна.
- 6.3.21.4. Хөрсний усны шугам сүлжээг нэмэгдүүлнэ.
- 6.3.21.5. Одоо байгаа Дэнжийн 1000-I, II, III Баруун уул, төв цэвэрлэх орчмын үерийн далан сувгийг шинэчлэн засварлана.
- 6.3.21.6. Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хамгаалалтын бүсийг нарийвчлан тогтоож тус бүсэд байгаа айл өрх, аж ахуйн нэгж байгууллагыг нүүлгэн шилжүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулан ажиллана.
- 6.3.22. Далан, суваг, шугам сүлжээний цэвэрлэгээ, засварын ажилд шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжөөр хангана.
- 6.3.22.1. Далан суваг, шугам сүлжээний цэвэрлэгээ, үйлчилгээ, засварын чанар сайжирч, хүн хүчний ажлын ачаалал буурсан байна.

УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГА

- 6.3.23. Хотын ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, усны алдагдлыг бууруулж, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.



- 6.3.23.1. Хотын баруун хэсэгт ус хангамжийн шинэ эх үүсвэр барьж, төв цэвэрлэх байгууламжийн хаягдал усыг гүн цэвэршүүлэн дулаан, цахилгаан станцуудын техникийн усны зориулалтаар дахин ашиглана.
- 6.3.23.2. Туул усан цогцолборын техник, эдийн засгийн үндэслэлийг эцэслэн дуусгаж, барилга угсралтын ажлын зураг төслийг боловсруулна.
- 6.3.23.3. Ундны усны эх үүсвэрийн гүний худаг, тоолуургүй айл өрхийг тоолууржуулж усны бодит хэрэглээг тооцож усны лабораторийн хүчин чадлыг өргөтгөн шинэчилсэн байна.
- 6.3.24. Ус хангамжийн усан сан, шугам сүлжээг шинээр барина.
 - 6.3.24.1. Хужирбулан, Толгойт, Их наран, Буянт-Ухаа 2 хороололд шинээр усан сан, шугам сүлжээ барьж ашиглалтад оруулна.
 - 6.3.24.2. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинээр барьж ашиглалтад оруулна.
- 6.3.25. Одоо байгаа ус хангамжийн усан сан, шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.
 - 6.3.25.1. Зүүн хойд бүсийн усан санг өргөтгөн шинэчилнэ.
 - 6.3.25.2. Налайх дүүргийн усан сан, насос станц, дамжуулах гол шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.
 - 6.3.25.3. Одоо байгаа ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.
- 6.3.26. Ус хангамжийн шугамыг шуудуу ухалгүй доторлох төслийг хэрэгжүүлж дуусгаж, зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулна.
 - 6.3.26.1. Зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулна.
 - 6.3.26.2. Ус хангамжийн шугамыг шуудуу ухалгүй доторлох төслийг хэрэгжүүлж дуусгана.
- 6.3.27. Шинээр цэвэрлэх байгууламж барьж ашиглалтад оруулах бөгөөд хуучин байгууламжуудад техник технологийн шинэчлэлт хийнэ.



- 6.3.27.1. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж, лаг хатаах байгууламжийг ашиглалтад оруулна.
- 6.3.27.2. Буянт-Ухаа орон сууцны хорооллын бохир ус цэвэрлэх байгууламжийн гадна дулааны шугамын нэмэлт ажлуудыг ашиглалтад оруулна.
- 6.3.28. Орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудад шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжөөр хангана.
 - 6.3.28.1. Цэвэр, бохир усны зөөврийн болон шугам сүлжээний засвар үйлчилгээний машин механизмаар хангалт хийж шугам сүлжээний засвар үйлчилгээнд зарцуулах хугацааг багасгаж, ус түгээх үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

ЭРЧИМ ХҮЧ

- 6.3.29. Цахилгааны шугам сүлжээг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлж, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлж, гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.
 - 6.3.29.1. Хотын төв, гэр хороолол, зуслангийн бүсийн цахилгаан хангамжийн түгээх сүлжээг шинэчилж, шинээр хуваарилах байгууламж, дэд өртөө барина.
 - 6.3.29.2. Налайх дүүрэгт 220/110 кВ-ын 2х125 МВА чадалтай транзит дэд станц барина.
 - 6.3.29.3. Улаанбаатар дэд станцын хүчин чадлыг 2х200 МВА болгон тоноглож, шинэчилнэ.
 - 6.3.29.4. Ботаникын цэцэрлэг, Баянхошуу, Их наран, Дамбадаржаа, ПРП нийт 5 иж бүрдэл 110/35/10 кВ-ын 2х40 МВА чадалтай дэд станц шинээр барина.
 - 6.3.29.5. Бага тойрог 110 кВ-ын цахилгаан сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
 - 6.3.29.6. Цахилгаан цэнэг хураагуурын 50 МВт/ц багтаамжтай станц барина.
- 6.3.30. Гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, стандартад



нийцүүлэн, нэгдсэн удирдлагын автомат системд холбоно.

6.3.31. Дулааны станц шинээр барих, өргөтгөх, технологийн шинэчлэл хийнэ.

6.3.31.1. Налайх дүүрэг, Дамбадаржаа, Дэнжийн мянга, Сэлбэ дэд төвийн дулааны станц шинээр барьж, ашиглалтад оруулна.

6.3.31.2. Амгалангийн дулааны станцыг 50 МВт-ын дулаан, цахилгаан хосолмол хүчин чадалтай болгож нэмэгдүүлнэ.

6.3.32. Дулааны гол магистраль шугамын урт, дулаан нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.

6.3.32.1. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн шугам сүлжээг шинээр барьж, нэмэгдүүлнэ.

6.3.32.2. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн төв магистраль шугамуудыг өргөтгөх шинэчлэх ажлыг гүйцэтгэнэ.

6.3.32.3. Орон сууцны хорооллуудын дулааны гол шугамууд, насос станцуудыг өргөтгөн шинэчилнэ.

6.3.33. Хатуу түлшний халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбох, хийн түлшинд шилжүүлнэ.

6.3.33.1. Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбоно.

6.3.33.2. Хийн түлшний дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулна.

6.3.33.3. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагын хатуу түлшний халаалтын зуухнуудыг хийн түлшинд шилжүүлнэ.

МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО

6.3.34. Мэдээлэл холбооны электрон автомат телефон станц, мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилгуудыг холбож, нэгдсэн том сүлжээ үүсгэн, зохион байгуулалтыг сайжруулна.

6.3.34.1. Мэдээлэл холбооны төв шинээр барина.

6.3.34.2. Худаг сувагчлалын байгууламж шинээр барина.



ТЭМДЭГЛЭЛ
